



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.ГАНТУЛГА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.29 № 04/37 ҮАГ-САГ/2014/09/СМА-ТМЭЗ

Зөрчил арилгах тухай

Хөдөлмөрийн яамны аппаратын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллага нь Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас ТӨХ-ны 2013 оны 217 дугаар албан бичгээр балансаас балансад шилжүүлсэн нийт 168.7 сая төгрөгийн өртөгтэй 3 ширхэг суудлын автомашиныг бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д: "Аж ахуй нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д ".....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн **Шаардах нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, холбогдох шийдвэрийг үндэслэн нийт 168.7 сая төгрөгийн үнэ бүхий суудлын 3 автомашиныг орлогод авч, данс бүртгэлд тусгах,
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэхийг Хөдөлмөрийн яамны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Гантулга, Санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ц.Долгоржав нарт хариуцуулав.

АУДИТОР



П.ЧАНЦАЛДУЛАМ